

Профессор. Ш.Содном
МУИС-ийн НШУС-ийн захирал
Докторант Галсандондог
МУИС-ийн НШУС

Сонгогчдын үйл байдлын өөрчлөлт: хүчин зүйл ба хандлага

Өгүүллийн товч утга: Орчин үеийн улс төрийн амьдралд гарч буй өөрчлөлт, түүн дотор сонгогчдын сонголтод нөлөөлдөг хүчин зүйлүүдийг нийгэм, сэтгэлзүйн талаас нь судалж гаргахыг эрмэлзэв. Мөн ардчилсан өндөр хөгжсөн орнууд болон ардчилсан шилжилт хийж буй орнуудын сонгогчдын санал өгөлтийн ялгаатай байдлын учир шалтгааныг нийгмийн суурь өөрчлөлт, улс төрийн институтуудын үйл ажиллагаа, нийгэм дэхь субкультуруудын харилцаны нөлөөлөл, үйлчлэлээр тодруулан гаргав.

Түлхүүр үг: сонгогчдын зан үйл, нийгэм сэтгэлзүйн хүчин зүйл, дэд соёл, намын адилсал, нийгэм-улс төрийн трансформаци,

Сонгогчдын үйл байдалд нөлөөлдөг хүчин зүйлс нь ардчилал хөгжиж буй орнуудын түүхэн ба хувьсал хөгжлийн онцлогоор тодорхойлогддог байна.

Сонгогчдын сонголтонд харьцангуй урт хугацаанд нөлөөлдөг социаль хийгээд нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлийг нийтлэг сонголтын ба түүхэн нөхцөлт хэмээн ангилж болох юм.

Нийтлэг сонголтод нөлөөлдөг хүчин зүйлд юуны өмнө хүн амын удам судрын хийгээд нас хүйсийн онцлогоор тодорхойлогддог демографи тодорхойлолтууд ордог. Эдгээр хүчин зүйлс нь хөгжлийн аль нэг үед түүхэн байдлаар нөхцөлддөг ч гэсэн аль ч орны сонгогчдын хувьд нийтлэг учир холбогдолтой байдаг байна.

Бусад хүчин зүйлүүд тухайлбал нийгмийн ангийн ялгарал ба боловсролын түвшингийн ялгаа зэрэг нь нийгмийн хөгжлийн тодорхой шатанд ихэсч эсвэл багасаж (энэ үед шинэ шинэ хүчин зүйлүүд үүсч байна уу гэмээр онцгой шинж тэмдгүүд илэрдэг ч гэсэн) байдаг учир түүхэн нөхцөлт шинжтэй юм. Харин улс төрийн намын лидер, нэр дэвшигчийн имидж, сонгуулийн компани, хэвлэл мэдээллийн хэргсэл зэргийн сонголтонд нөлөөлдөг богино хугацаат хүчин зүйлс гэж үздэг.

1. Ардчилсан хийгээд шинээр хөгжиж буй орнуудын сонгогчдын үйл байдалд гарч буй үндсэн хандлагыг авч үзье.

Сонгогчдын үйл байдлын социологийн загварын үүднээс бол нийгмийн ялгарлын шинэ үндсүүдийн үүсэл нь барууны орнуудад явагдсан модернизацийн явцтай холбоотой байв. Өөрөөр хэлбэл шинэтгэлийн үед урьд өмнө оршин байсан шашин хоорондын зөрчил, хот ба тосгон, төв ба зах хязгаар нутгийн ялгаа нь хүн амын улс төрийн сонирхолд өөрийн илрэлээ олох болсон. Капитал ба хөдөлмөрийн хоорондын зөрчил ч энэ үед бүрэн утгаараа илрэн үйлчилсэн.

Нийгмийн эдгээр хүчин зүйлсийн улс төрийн түвшин дэхь нөлөөлөл нь урт удаан хугацаанд барууны ардчилуудын улс төрийн талбар ба бүтцийг тодорхойлж, үзэл суртлын хагарлын байдлаар илэрч байв. Энэ нь эдийн засгийн либерализм ба нийгмийн баримжааны талынхны, католик ба протестант шашны сүсэгтнүүд ба шүтлэггүй хүмүүсийн хоорондын улс төрийн ялгаатай үнэлэмж ба дэд соёлуудын байдлаар оршиж байв.

Тэрчлэн улс төрийн төлөөллийн институтууд бүрэлдэн төлөвших хэрээр нийгмийн хүчин зүйлсийн нөлөөлөл идэвхжсэн байна. Нийгмийн бүлгүүд нь улс төрийн намын нийгмийн бааз суурь бүрэлдэх үйл явцыг ихээхэн хөнгөвчилж, намуудын улс төр, зохион байгуулалтын үндсийг бүрдүүлж, санхүүгийн хийгээд сонгуулийн үйл ажиллагааг нь дэмжих болов. Ийнхүү нийгмийн хөгжлийн

тодорхой үе шатанд намууд бүлгийн ашиг сонирхлыг улс төрийн тавцанд төлөөлөн илэрхийлэх үүрэг гүйцэтгэх болсон.

С. Липсет, С.Роккан нарын хийсэн социологийн судалгаа, сонгогчдын нийгэм-сэтгэл зүйн загварыг баримжаалсан санал асуулгууд, статистикийн судалгаанууд ХХ зууны дунд үед барууны орнуудын сонгогчдын нам-улс төрийн эрхэмлэл харьцангуй тогтвортой байгааг нотолж байв.

Дээрх судалгаануудын дүнг үндэслэн сонгогчдын нийгмийн ялгарлын нөлөөлөл нь дараах ерөнхий чиг хандлагаар илэрдэг гэсэн дүгнэлт хийж байлаа. Үүнд: ажилчид ихэнхдээ зүүний намуудыг түших байдлаар саналаа өгч байхад харин шашны субкультурын төлөөллүүд шашны чиглэлтэй болон консерватив намд, өмчтнүүд ба хувийн аж ахуй эрхлэгчид барууны намд, хөдөөгийн оршин суугчид барууны уламжлалт чиглэлийн намд, хотынхон зүүний намд саналаа өгдөг байх жишээтэй. Гэхдээ энэхүү ажиглагдсан хандлага нь нэг мөр нотлогдоогүй бөгөөд үргэлж ийм хэлбэрээр илэрч байсангүй.

1960-1970-аад онд аж үйлдвэржсэн нийгмийн бүтцийн хямралын нөлөөн дор явагдсан нийгэм-улс төрийн трансформацийн үйл явцтай холбоотойгоор сонгогчдын үйл байдалд нөлөөлдөг шинэ хүчин зүйлүүд идэвхжих, тэрчлэн өмнөх үеийн "сонгодог" ялгарлын нөлөөллийн шинж чанар, орчин өөрчлөгдөж байгаа нь ажиглагдаж эхэлсэн байна.

Барууны орнуудыг хамарсан аж үйлдвэржсэн нийгмийн хямрал энэ нийгмийн уламжлалт анги, бүлгийн задралыг дагалдуулж, нийгмийн социаль бүтцийг нарийн төвөгтэй болгож, хүн амын шинэ дунд давхраа бий болж, социаль хийгээд газар зүйн шилжилт хөдөлгөөн нэмэгдсэн. Өнөөдөр сонгогчдын улс төрийн эрхэмлэлд нийгмийн уламжлалт хүчин зүйлүүдийн нөлөө мэдэгдэхүйц буурах хандлага ажиглагдаж байна¹.

Эрдэм шинжилгээний ном зохиолд нийгмийн энэ онцлог үзэгдлийг янз бүрээр тайлбарлаж байна. Зарим зохиогчид нийгэм-статусын хамаарал нь сонгогчдын сонголтонд мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн хэвээрээ байгаа үзэж байхад, нөгөө хэсэг нь харин зөвхөн нийгэм статусын хамаарлын үндэс л өөрчлөгдсөн гэж үзэж байна. Судлаачид нийгмийн статусын хамаарлын шинэ шалгуурыг гаргаж ирж байгаа бөгөөд энэ нь боловсролын түвшин ба мэдээллийн хангамж, хувийн ба нийгмийн секторын хоорондын ялгаа юм. Эцсийн үр дагавар нь социаль бүтцийн хийгээд сонгогчдын үйл байдлын илүү нарийн төвөгтэй загвар бий болж болох юм.

Гэвч нийгмийн бүтцийн энэ онцгой нарийн төвөгтэй байдал, түүний хөгжлийн хандлагыг нь тооцсон ч нийгэм-бүлгийн хүчин зүйл бүхэлдээ сонгогчдын сонголтонд нэг адил нөлөөтэй бус байна. Скандиновын намын системд (Норвеги, Швед, Финлянд, Дани, Исланд г.м) нам-улс төрийн эрхэмлэл, нийгмийн статусын хоорондын корроляци харьцангуй хүчтэй байхад АНУ, Канад, Японд хамгийн бага байна. Гэхдээ бүх орнуудад энэ үзүүлэлтийн ач холбогдол буурах хандлага ажиглагдаж байгаа юм.

Сүүлийн 10 жилд шашны хүчин зүйлс ч сонгогчдын үйл байдалд тун бага нөлөөлж байна. Нийгмийн модернизаци шашин шүтлэгийн холбоог сулруулсан. Амьдралын хэв маяг өөрчлөгдөхийн хэрээр сүсэгтнүүдийн идэвхийн түвшин буурч, ингэснээр нийгмийн амьдрал сүм хийдээс алгуур хөндийрөх үйл явц явагдаж байна. Үндэстнүүдийн хувьд ялгаа зөрөө их байгаа ч гэсэн (жишээ нь, Франц, Испани, Их Британи, Скандиновын орнуудад иргэдийн шашин шүтлэгийн бүтэц гомоген шинжтэй бол Герман, Голланд, АНУ-д гетероген шинжтэй учир

¹ Dalton.R.J.Political Cleavages, issues and Electoral Change / Comparing Democracies. Elections and Voting in Global Perspective. Thousand Oak, 1996.P.323

эдгээр оронд шашны ялгарал харьцангуй хүчтэй байдаг) энэ хүчин зүйлийн нөлөө багасах хандлагатай байгаа нь нийтлэг зүйл юм¹.

Бүс нутгийн болон оршин суугаа газрын онцлог, арьсны өнгө, угсаатны хамаарал зэрэг нийгмийн бусад хүчин зүйл бас л төдийлөн нөлөөтэй бус байна. Бүс нутгийн хийгээд угсаатны хоорондын зөрчил үе үе идэвхждэг зарим орнуудын хувьд эдгээр хүчин зүйл ач холбогдолтой мэт боловч (Тухайлбал, Их Британи, Бельги, Канад болон баруун Европын зарим оронд цагаач иргэдтэй холбоотойгоор бүс нутаг, угсаатан хоорондын зөрчил ажиглагддаг ч) бүхэлдээ сонгуулийн санал өгөлтөнд тэдгээрийн үзүүлэх нөлөөлөл их биш болох нь харьцуулсан судалгаагаар нотлогдож байна.² Эрчимтэй явагдаж буй шилжилт хөдөлгөөн, түргэн хурдацтай хөгжиж байгаа мэдээллийн хэрэгсэлийн нөлөөгөөр хот, тосгоны хоорондын ялгаа, зөрчлийн гүйцэтгэх үүрэг ч буурч байна.

Гэхдээ иргэдийн санал өгөлтөнд дээр дурьдсан нийгмийн хүчин зүйлүүдийн нөлөөлөл багасч байгааг зөвхөн хандлага байдлаар л авч үзэж байгааг тэмдэглэх хэрэгтэй. Учир нь барууны орнуудын нийгмийн хөгжлийн өнөөгийн үе шатанд ихээхэн нарийн төвөгтэй социаль орон зайн дотор нийгмийн хурц асуудлууд (жишээлбэл, шинэ ядуучуудын асуудал, гэмт хэрэг, мансууруулах бодисын хэрэглээ гэх мэт) хадгалагдсаар байна. Бүхэлдээ нийгэм-бүлгийн хүчин зүйлүүд сонгогчдын үйл байдалд өнөөдрийг хүртэл тодорхой нөлөө үзүүлсээр байна.

Улс төрийн эрхэмлэлийн хувьсалд гарч буй өөр нэг хандлага бол сонгогчдын намын адилсал сулрах, үзэл суртлын ялгаа багасах, богино хугацаат хүчин зүйлийн нөлөө (улс төрийн лидерийн имидж) өсч байгаа явдал юм. Энэ хандлагыг орчин үеийн социаль өөрчлөлтүүд, тэрчлэн үнэт зүйлсийн бүтцэд гарч буй хувьсал, засаглалын систем дахь уламжлалт намуудын интеграцчилал, түүнд зохицсон намын олигархичлал, ихэнх намуудын хувьд намын байгууллага, түүний нийгмийн бааз суурийн хоорондын холбоо суларч байгааг зохицуулах чадваргүй байдал, ер нь улс төрийн үйл байдал, үйл ажиллагаа хэт бодьгалчлагдсан явдалтай холбож үзэж болох юм. Улс төрийн төлөөллийн институт болох намд сонгогчдын итгэх итгэл сулраад зогсохгүй сонгуулийн үр дүнд намын адилсалын хүчин зүйлийн үзүүлэх нөлөөлөл буурч байна. Өөрийгөө тодорхой нэг улс төрийн намтай адилсгадаг сонгогчдын тоо цөөрч байгаагаас гадна тогтворгүй сонгогчдын тоо, аль ч намыг дэмждэггүй хүмүүсийн тоо өсч байна.

Энэ хандлагыг тоон үзүүлэлтээр илэрхийлж болох юм. 1960-аад оны эхээр АНУ-д санал өгөлтөнд намын адилсалын нөлөө харьцангуй өндөр байсан бөгөөд намыг тууштай дэмжигчд 35-37 хувьтай байв. 1980-аад онд энэ үзүүлэлт нийт сонгогчдын дөрөвний нэг болтлоо буурсан. Өнөөдөр барагцаагаар Америкчуудын тавны нэг нь сонгуульд баримталх улс төрийн эрхэмлэлээ өөрчилж байна. Тэгвэл 1960-аад онд улс төрийн аль нэг намыг хатуу дэмждэг хэсэг Их Британид сонгогчдын 40 хувь байсан бол 1980 онд 20 хувь болж 50 хувиар буурсан байна.³ Францад хүн амын улс төржилтийн түвшин өндөр, энэ ч чанараараа намын адилсалын уламжлал хүчтэй байдаг. 1978 онд энэ орны насанд хүрсэн хүн амын 80 илүү хувь нь өөрийгөө улс төрийн аль нэг намын адилсалтай гэж үзсэн байна. Гэтэл 1985 онд сонгогчдын энэ хувь 60.7 хувь болж

¹ Dalton.R.J.Political Cleavages, issues and Electoral Change / Comparing Democracies. Elections and Voting in Global Perspective. Thousand Oak, 1996.P.325,327

² Dalton.R.J.Political Cleavages, issues and Electoral Change / Comparing Democracies. Elections and Voting in Global Perspective. Thousand Oak, 1996.P.325, 328-329

³ Dalton.R. Citizen Politics in Western Democracies: Public Opinion and Political Parties in the United States, Great Britain, West Germany and France. Chatham, 1988.P.188

буурчээ.¹ Бусад орнуудад ч ийм үйл явц явагдаж буйг судалгааны дүнгүүд харуулж байгаа юм.

Судлаачид намыг тууштай дэмжигчид цөөрч байгааг барууны орнуудын улс төр, социаль хүрээнд гарч буй өөрчлөлттэй холбон үзэж байна. Тэд энэ хандлагыг улс төрийн институтийн хувьд намын гүйцэтгэх үүрэг роль өөрчлөгдөж байгаа; намын хэмээн үзэж ирсэн зарим чиг үүргийг бусад институт хэрэгжүүлэх болсон; сонирхолын бүлэг олноор бий болж тэдгээр нь сонирхол илрүүлэх, нэгтгэн боловсруулах, шийдвэр гаргах түвшинд хүргэх үүргийг намаас гадуур зохион байгуулан хэрэгжүүлэх болсон; мэдээллийн хэрэгсэл улс төрийн системд оролтын чиг үүргийг идэвхтэй гүйцэтгэх болсон; намууд сонирхлын артикуляцийн чиг үүргээ урьдын адил бүрэн хэрэгжүүлэхэд хүч мөхөсдөх болсон; сонгогч өөртөө тулгарсан ээдрээтэй асуудлын дунд чиг баримжаа байр сууриа тодорхойлохын тулд намд ханддагаа больсон; сонгогчдын боловсролын түвшин өссөн, улс төрийн бодлогын асуудлын учрыг ойлгох чадвартай иргэд олширсонтой холбон тайлбарлаж байна.

Гэхдээ намын хийгээд үзэл суртлын адилсал суларч тэдгээрийн нөлөө буурч байгааг зөвхөн хандлага байдлаар л авч үзэж болох юм. Харин сонгогчдын үйл байдалд эдгээр хүчин зүйлүүд нөлөөлсөн хэвээрээ байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Сонгогчдын үйл байдлын хувьслын өөр нэг хандлага бол улс төрийн чиг баримжаа бүрэлдэн төлөвших процесс рациональчлагдаж, сонгогчдын 10-15 хувийг бүрдүүлдэг "шинэ сонгогч" гэсэн бүлэг үүсч буй явдал юм. Сонгогчдын энэ бүлэг нь сонгуульд тогтмол оролцдог ч гэсэн юуны өмнө улс төрийн эрхэмлэлийн хувьд хөдлөнгө, тогтворгүй байдлаараа онцлог юм. Тэдний төлөөлөл нь "нийгмийн төв хэсэг" буюу хүн амын нэлээд боловсролтой дунд давхраанаас гаралтай бөгөөд насны хувьд залуу, мэдээлэл сайтай, үзэл сурталд үл итгэх хандлагатай, засгийн газар, нээлттэй улс төрд эерэг байр суурьтай. Үйл байдлын хувьд тэд сонгууль, сонгуулийн процетур, үр дүнд хэрэглэгчийн байр сууринаас ханддаг.

Сонгогчдын ийм шинэ бүлэг бий болж байгаа нь сонгогчдын сонголт рациональчлагдаж байгаагийн тусгал юм. Улс төрийн эрхэмлэл бүрэлдэх түвшинд энэ үйл явц нь сонгуулийн үед хийх сонголтонд бодлогын тодорхой асуудлаар, ялангуяа эдийн засгийн асуудлаарх иргэдийн санал, байр суурийн нөлөөлөл нэмэгдэж буйгаар илэрч байна. Улс төрд гарч буй зарим шинэ үйл явц, шинэ асуудал дэвшүүлсэн намууд гарч ирсэн, сонгуулийн үед бодлогын асуудлаар үзэл бодлын маргаан ерөнхийдөө сэргэж идэвхжсэн, иргэдийн мэдлэг боловсрол нэмэгдсэн, тэд өнөөгийн олон асуудлыг сонирхох болсон, улс төрийн элит олон нийтийн санаа бодолд илүү анхааралтай хандах болсон зэрэг нь сонгогчдын дунд асуудлаар санал өгөгчдийн тоо (рациональ сонгогчийн тоо) нэмэгдэхэд түлхэц болж байна.

Нийгмийн бүтцийн "сонгодог" ялгарал ба намын адилсалын хүчин зүйлийн бууралттай зэрэгцээд нийгмийн хөгжлийн аж үйлдвэржсэний дараах шат, үнэт зүйлийн пост материаллаг системийн үүсэл хөгжилтэй уялдан улс төрийн эрхэмлэлийн шинэ үндэс суурь бий болж байна. Амьдралын чанар, хүрээлэн буй орчин, эмэгтэйчүүдийн эрхийн тухай асуудалд улам бүр олон сонгогч анхаарал тавих боллоо.

"Шинэ" үнэт зүйлс, шинэ асуудлын баримжаалал юуны өмнө нийгмийн ялгаралын уламжлалт системд хамгийн бага татагдан орсон: шинэ дунд анги, боловсролтой хэсэг, залуучууд, шашингүйчүүдэд илүү хамааралтай байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн ийм давхрааны төлөөллөөс " шинэ сонгогчид " бүрэлдэх процесс явагдаж байна.

¹ Charlot.J.La transformation de l'image des parties politiques francais// Revue francais de science politique.N.1.P.6; Le Monde.1985.23 oct

Сүүлийн 10 гаруй жилд ардчилал хөгжсн орнууд дахь улс төрийн чиг баримжааны хувьсал нь улс төрийн эрхэмлэлийн удаан хугацааны хүчин зүйлүүдийн нөлөөллийн бууралт, нэр дэвшигчийн имидж, тодорхой асуудлаарх сонгогчдын байр суурь зэрэг богино хугацаат хүчин зүйлсийн нөлөөллийн өсөлтөөр тодорхойлогдож байна. Үүний зэрэгцээгээр нийгэм-бүлгийн хүчин зүйлс ба ялангуяа улс төрийн ардчиллын хүчин зүйл сонгуулийн үеийн улс төрийн чиг баримжаа бүрэлдэхэд голлох үүрэг гүйцэтгэсэн хэвээрээ байгаа харьцуулсан судалгаануудын үр дүн харуулж байна.

Барууны орнуудад бүрэлдсэн сонгогчдын үйл байдлын онолын үндсэн загварыг шилжилтийн нийгэмд хэрэглэж болох эсэх асуудлаар судлаачдын дунд ялгаатай байр суурь ажиглагддаг. Санал хураалтын тоон утгатай томъёолол нь сонгуулийн үр дүнг урьдчилан хэлэх чадвартай эсэхэд эргэлзэх хандлага нийтлэг байна. Харин Оросын судлаач Г.В.Голосов "Барууны ардчилсан орнуудад боловсрогдсон үндсэн гурван онол нь Оросын нөхцөлд ч хэрэгжиж байгаа бөгөөд хамгийн үр ашигтай нь "нийгмийн сэтгэл зүйн хандлага" дараа нь "эдийн засгийн санал өгөлтийн онол", эцэст нь социологи хандага юм" гэж үзсэн байна.

Ардчилал, зах зээлийн харилцаанд шилжээд 10 гаруй жил болсон посткоммунист орнуудад явагдсан улс төрийн сонгуулийн үед хуримтлагдсан сонгогчдын үйл байдлын талаарх статистик тоо баримт, социологийн судалгааны дүнг үндэслэн тэдгээр орны сонгогчдын сонголтонд гарч байгаа зарим нэг тогтвортой хандлагыг авч үзэх бололцоотой юм. Гэхдээ эдгээр хандлагыг барууны орнууд дахь онолын загваруудад бүрэн багтаан тайлбарлах аргагүй юм.

Үнэндээ "социологи хандлага" нь нийгмийн бүтцийг нилээд сайн судалсан, тогтворжсон социаль бүтэцтэй хувь хүний нийгмийн байр байдал түүний улс төрийн тогтсон хандлагын хоорондын хамаарлыг урьдчилан хэлж болохуйц нийгмийн хувьд томъёологдсон гэдэг нь тодорхой юм. Судалгаанаас үзэхэд харин посткоммунист орнууд дахь улс төр, эдийн засаг, социаль хүрээг хамарсан гурвалсан шилжилт нь нийгмийн бүтцийг задалж урьдчилан таамаглахааргүй байдалд хүргэж байна. Тэрчлэн хувь хүний нийгмийн байр байдал тэдний сонгуулийн эрхэмлэлийн хоорондын холбоо хамаарал тодорхойгүй, тогтвортой бус байдлаас болж зарим шинжээчид олонх шинэ ардчилуудад нийгмийн мэдээжийн илүү тодорхой хүчин зүйлүүд ч санал өгөлтөнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй байна. Тэнд иргэд сонголтоо үзэл суртлын шинж чанартай төсөөлөл ба нэр дэвшигчийн хувийн шинжийг гол шалгуур болгон хийж байна гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Ер нь барууны сонгогчдын үйл байдлын судалгаанд нэгэнт тодорхой байдаг өмчтөн ба ажилчдын хоорондын ялгарал ч посткоммунист орнуудад хэрэг дээрээ ажиглагдахгүй байна.

Гэхдээ эдгээр оронд сонгогчид ба улс төрийн институтуудын хоорондын холбоо харилцааны зарим хэв маяг дөнгөж бүрэлдэх шатандаа байна. Үр дүн нь харилцан адилгүй ч гэсэн энд зах зээлийн эдийн засгийн нөхцлийг санагдуулахуйц эдийн засгийн загвар бий болгох нарийн төвөгтэй зорилтыг хэрэгжүүлж байна. Ийм учраас ардчилсан институтууд болон зах зээлийн эдийн засгийн цаашдын хөгжлийн явцад сонгогчдын улс төрийн эрхэмлэл бүрэлдэн төлөвших социаль үндэс суурь бэхжинэ хэмээн хүлээж болох талтай. Иймэрхүү итгэл муутай таамаглал хийхэд эдийн засгийн өөрчлөлтийн үйл явц нь нийгмийн тэгш бус байдлын өсөлттэй холбогдож үр дүн нь олон янз байгаагаас гадна бүр

¹ Голосов, Г.В. Поведение избирателей в России: теоретические перспективы и результаты региональных выборов. Полис. 1997. № 5

зах зээлийн үеийн нийгмийн бүлгүүдийн хэт туйлширсан байдлыг бий болгож буй зэрэг нөхцөл байдал нөлөөлж байна¹.

Посткоммунист орнууд дах сонгогчдын үйл байдлын нийгэм-сэтгэл зүйн хандлагад арга зүйн болон техникийн олон асуудалтай тулгардаг "Намын адилсал" гол анхаарал татаж байна. Барууны ардчилсан орнуудад намын адилсал бие хүний улс төрийн нийгэмшлийн процесст бүрэлддэг байна. 60-аад онд хэд хэдэн ардчилсан улсуудад явуулсан судалгаагаар хүүхэд бүр 10-11 наснаасаа эцэг эхийнхээ дэмждэг тодорхой нэг намын хүндэтгэх үзэлтэй болж, тэр нь амьдралынх нь туршид удаан хугацаагаар хадгалагддаг гэсэн дүгнэлт гарчээ. 1. Социалист системд багтаж байсан орнуудын хувьд сонгогчдод удаан хугацаагаар нөлөөлж чадах ганц боломжтой нам нь эрх барьж байсан коммунист намууд байлаа. Шинээр үүссэн улс төрийн намууд тэдгээрийн тогтвортой бус байдал нь өөрийн тогтвортой сонгогчдыг бүрдүүлж чадаагүй байна. Энэ нь намын адилсал гэдэг ойлголтыг цэвэр утгаар нь тэдгээр оронд хэрэглэж болох эсэх талаар маргаан үүсгэдэг. Оросын судлаач Ю.Д.Шевченко "Орчин үеийн Оросын сонгогчдын хувьд зөвхөн үзэл суртлын бааз сууринд тулгуурласан ардчиллын тухай л ярьж болно. Өнөөдөр улс орон даяар сонгууль нь ч сонгогчид нь ч тогтворгүй байна"² гэжээ. Энэ үйл явц үнэндээ сонгуулиас сонгуулийн хооронд оршин тогтдог олон жижиг намуудын байр суурь, үзэл баримтлалын тодорхой бус байдлаас үүдэлтэй. Ийм учраас үзэл суртлын аль нэг блокоос нөгөөд, нэг намаас нөгөө намд шилжин санал өгөгчдийн тоо маш өндөр байна. 1990-ээд онд хийгдсэн судалгаагаар сонгогчдын хувьд улс төрийн нам өөрөө чухал биш харин үзэл суртал- улс төрийн байр суурь л чухал бөгөөд тэрээр дараагийн сонгуульд өөр намд санал өгөх нь илүү дээр гэж бодож болох ч үзэл суртлын өмнөх чиг баримжаа нь хэвээр хадгалагдан үлддэг гэжээ³.

Р.Роуз, У.Мишлер нар Европын посткоммунист орнуудад намын сөрөг адилсал давамгайлдаг гэж үзсэн байдаг. Энэ нь сонгогчийн хувьд аль намд ер нь санал өгөх хэрэггүй вэ? гэдгээ ойлгох нь хялбар гэсэн үг юм. 1995 онд Унгар, Польш, Румын болон Словенид явуулсан судалгаанаас харахад судалгаанд оролцогчдын 23 хувь эерэг, 77 хувь нь сөрөг адилсалтай байсан байна. Үүнийг олон жил оршин тогтносон коммунист нам, түүний үзэл суртал, нэр хүнд ихээхэн доройтсонтой холбож үздэг. Судлаачид посткоммунист блокийн орнууд дахь намын адилсалыг сөрөг, хаалттай, ноомой, нээлттэй гэсэн дөрвөн хэв шинжид хуваадаг.

Сөрөг хэлбэрийн адилсалын үед сонгогчид ямар намын төлөө хэзээ ч санал өгөхгүй гэдгээ хэлж чадах боловч харин ямар намд саналаа өгчихсөн болох талаар хариулахад бэрхшээлтэй байдаг байна. Судалгаанд оролцогчдын 52 хувь нь ийм хэв маягийн адилсалтай байжээ. Хаалттай хэв маягийн үед сонгогчдод эерэг ба сөрөг адилсалын аль аль нь байдаг боловч сонголт хийхдээ ихээхэн туйлшрах хандлагатай бөгөөд нийт сонгогчдын 25 хувийг эзэлдэг байна. Нээлттэй хэлбэрийн адилсалын үед сонгогчид тодорхой намуудыг илт дэмждэг, гэхдээ ямар намд саналаа өгөхөө хэлдэггүй. Г.Алмонд, С.Верба нар Америкчуудын 82 хувь нь нээлттэй хэв маягийн ардчилалтай гэж тодорхойлсон байдаг. Посткоммунист орнуудад хийсэн судалгаагаар сонгогчдын зөвхөн 5 хувь нь энэ хэлбэрт багтдаг дүн гарчээ. Эцэст нь ноомой хэлбэрийн адилсалтай сонгогчид эерэг ч биш сөрөг ч биш үнэлэмжтэй, тэд судалгаанд оролцогчдын 18 хувийг эзэлдэг байна.

¹ Эванс.Д. Уайтфилд.С. Социально-классовый фактор политического поведения россия// Социс.М., 2000. № 2.С.39-51

² Harrop M. and Miller W.Z. 1987. Elections and Voters. A Comparative introduction. Hampshire and L., 1987

³ Шевченко Ю.Д. Узак. Соч.

Посткоммунист орнуудын сонгогчдын үйл байдлыг тайлбарлахад хамгийн тохиромжтой нь эдийн засгийн санал өгөлтийн онол байж болох юм. Онолын энэ хандлагыг хэрэглэхэд хүргэж буй нэг асуудал бол дээрх орнуудад бүгдэд нь хэрэг дээрээ коммунист дэглэм нуран унах, ардчилалд шилжих үйл явц нь иргэдийн ч, төр улсын ч эдийн засгийн нөхцөл байдлыг үлэмжхэн доройтуулсан явдал юм. Нийгэм нь байнгын хямралд автагдаж, засаглалын ямар ч байгууллагын үйл ажиллагааг барууны сонгогчдод зуршмал байр сууринаас үнэлэх бололцоогүй болсон. Гэтэл шинэчлэгчид, илүү гүнзгий өөрчлөлтийн талынхан сонгуульд ихэвчлэн ялалт байгуулдаг байна.

Ийм нөхцөл байдлаас үүдээд зарим судлаачид (Г.Китчельт) барууны орнуудын хүн амаас ялгаатай нь гэвэл шинэ ардчилуудын иргэд нэгдүгээрт, өөрийгөө бодсон, хоёрдугаарт, хэтийг харсан санал өгдөг гэсэн таамаглал хийсэн байдаг. Энэ нь тухайн сонгогч хэн нэгэн улс төрч болон намыг дэмжсэн санал өгснөөр өөрийн хувийн эдийн засгийн байдлыг хэрхэн сайжруулж болох талаар тооцдог гэсэн үг юм.

Энэ дүгнэлтийн тухайд санал нийлдэг ба нийлдэггүй судлаачид бий. Жишээлбэл Я.Фидрнукийн судалгаа Г.Китчельтийн дүгнэлтийг дэмжиж байна. Сонгогчдын шийдвэр нь санал өгөх үеийн тухайн орны эдийн засгийн байдал, цаашид хийгдэх эдийн засгийн шинэтгэлийн боломж үр өгөөжөөс хамаардаг тухай таамаглалд үндэслэн Я.Фидрнук Зүүн Европийн дөрвөн орон - Чех, Унгар% Польш, Слованийн хэд хэдэн сонгуульд сонгогчдын санал өгөлтийн хандлагыг шинжилж үзсэн байна. Судлаач эдийн засгийн шинэтгэл, сонгуулийн үр дүнгийн хоорондын хамаарал хүчтэй байгааг харуулжээ. Гэвч шилжилтийн үеийн улс орнуудын сонгогчдын үйл байдал өнгөрсөн үе рүүгээ хандсан (ретроспектив) биш харин ч ирээдүйд тэдний амьдралыг бололцооны болгож чадах намыг сонгогчид дэмжиж байв¹.

Гэвч иймэрхүү дүгнэлтийг шүүмжлэгчид олон байна. Тухайлбал Г.Голосов "Ардчиллын туршлага багатай Зүүн Европын сонгогчид нь барууны орнуудын иргэдийн ч хүрч чадахааргүй мэдээллийг олж авч, өөрсдийн сонголтын үр дүнг урьдчилан хэрхэн яаж тооцож чадаж байна вэ?"² гэсэн асуултыг тавьж байгаа юм.

Түүнээс гадна посткоммунист орнууд дахь зарим баримт алсын хараатай, болон хувийн эдийн засгийг бодолцсон (хэтэвчний) санал өгөлтүүдийн тухай дүгнэлтийг няцааж ретроспектив болон социотрэн санал өгөлтүүдийг анхааруулж байна.

¹ Fidrmuc J. Economic of voting in post-communis countries // Electoral Studies. 2000. № 19. P.215

² Голосов. Г. В. Партийные системы России и стран Восточной Европы: генезис, структуры, динамика. М., 1999. С.97